

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

\2016.10.25-2016.11.25\

НЭГ:УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Улсын их хурлын гишүүн М. Энхболдын ивээл дор зохион байгуулагдаж байгаа сумын шатрын аварга шалгаруулах сонирхогчдын тэмцээнийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулж:

Эрэгтэй төрөлд: 1-р байранд: Д. Сүхбаатар 2-р байранд, Б. Энхбаяр, 3-р байранд Г. Сүхбаатар нар шалгарч аймгийн тэмцээнд оролцох эрхтэй болоод байна.

Эмэгтэй төрөлд: 1-р байранд: Б. Энхгэрэл 2-р байранд Н. Баясгалан, 3-р байранд Б. Энхчимэг нар шалгарч Б. Энхгэрэл аймгийн тэмцээнд оролцох эрхтэй болоод байна.



Аймгийн хурц арслан А. Түдэвдавга агсаны нэрэмжит үндэсний бөхийн цол олгох тойргийн барилдааныг сумын бөхийн холбоо, гэр бүл үр хүүхдүүд нь зохион байгуулж Содбаяр түрүүлж сумын заан цол, шөвгөрсөн Г. Золбоо сумын начин цол хүртлээ.



А. Түдэвдавга агсаны нэрэмжит шагайн багийн харвааны тэмцээнийг сумын шагайн холбоо, гэр бүл үр хүүхдүүд нь зохион байгуулж Одсүрэн ахлагчтай баг түрүүлж, Мөнхбат ахлагчтай баг хоёрдугаар байранд, Эрдэнэсоёл ахлагчтай баг гуравдугаар байранд орлоо.



Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны Улсын байцаагч Н. Намуунцэцэгийн эмчилгээний зардалд зориулан “Сэтгэлийн өргөл” аяныг өрнүүлж аяны хүрээнд хандивын тоглолт, гар бөмбөгийн бооцоот тэмцээнийг зохион байгууллаа.



Гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй, эмэгтэй төрлөөр нийт 22 баг оролцлоо.



ХОЁР: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Нэг.Хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг ТЭГ болгоё уриатай “Нэг санаачилга-нэг ажил” үндэсний аяны хүрээнд олон нийтийн оролцоо, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор сумын 3-р сургуультай хамтран 2016 оны 11 сарын 09-нөөс 11 сарын 15-ныг хүртэл дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

Нэгдүгээрт: Багш, сурган хүмүүжүүлэгчдээр дамжуулан хүүхэд, эцэг эхчүүдэд Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудтай уялдуулан хүчирхийллийн хор уршгийн талаар мэдлэг олгох, хүмүүжлийн шинэлэг арга барилыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газраас сумын багш нарын дунд “ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТЭГЛЭЖ, ХҮМҮҮЖЛИЙН ЭЭРЭГ ХАНДЛАГЫГ ТҮГЭЭЭ” сэдэвт бүтээлч уралдааныг зарлан зохион байгуулж дүгнэн нэгдүгээр байрыг “Өөрчлөлт” баг, хоёрдугаар байрыг “Эрүүл нийгмийг хүсэгчид” баг, гуравдугаар байрыг “Хамтын хөгжил” баг тус тус эзэлж, Өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Хоёрдугаарт: 3-р сургуулийн сурагчдын дунд “ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТЭГ БОЛГОЁ” арга хэмжээг 2016 оны 11 сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 6-12 дугаар ангийн сурагчид хүүхдийн “Үе тэнгийнхний гадуурхал, дарамтыг зогсооё” сэдэвт жүжигчилсэн тоглолт хийж, шилдгүүдээ шалгарууллаа.

Гуравдугаарт: “ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТЭГ БОЛГОЁ” арга хэмжээний үеэр хүчирхийллийн улмаас амь насаа алдсан хүүхдүүдийг хүндэтгэж, 30 секунд чимээгүй зогсолт хийж, хүндэтгэл үзүүллээ.



Хоёр.Сумын Хүүхэд хамгааллын хамтарсан баг 2016 оны 11 сарын 21-ний өдөр хуралдаж 2016 онд хийсэн ажлын тайлан, үр дүнг хэлэлцэж, цаашид хийгдэх ажлын чиглэлийг тодорхойлон шинээр кейс 3, 4-ийг нэмэхээр шийдвэрлэж, багийн гишүүд хариуцсан ажил чиглэлийн дагуу үүрэг даалгавраа авлаа.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:


Гуравдугаар сургууль:

Нэг. Сургуулийн хэмжээнд Онол практикийн бага хурал 10 дугаар сарын 27, 28-нд бүх багш нарын дунд явагдав. “Хүүхдийн хөгжил төлөвшил хандлагын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудал арга зам” сэдэвтэй илтгэлд 21 илтгэл оролцож шилдгүүдээ шалгарууллаа.

Хоёр.БСШУС-ын яамны сайдын 2016 оны 09 сарын 16 өдрийн А/43 тушаал буюу хичээлийн цагаар багш, суралцагчийг гар утасны хэрэглээгээ зогсоох зорилгын хүрээнд “Ухаалаг гар утасны хэрэглээг зогсооё” уриан дор гар утасны хэрэглээг зөв зохистой хэрэглэх талаар үйл ажиллагааг хэрэгжүүлээд ажиллаж байна.Үүнд кабинетын системээр хичээллэх үедээ хичээл орох анги танхимдаа орохдоо багш, суралцагчид гар утсаа унтраах буюу утасныхаа дууг хааж гар утас хийх саванд байршуулснаар хичээлийн үйл ажиллагааг явуулж байна.




Гурав. 2016-2017 оны I улирлын дүн мэдээ нэгтгэгдэн гарлаа. Энэ хичээлийн I улирлын дүнг өмнөх хичээлийн жилийн I улирлын дүнтэй харьцуулан дүгнэлт хийхэд 2%-иар буурсан үзүүлэлттэй байна.



Хичээлийн жилийн II улирал эхэлсэнтэй холбогдуулан багш нар хичээлийн төлөвлөлтийг сайтар нягтлан боловсруулж ээлжит хичээлийн бэлтгэлийн ханган ажиллаж байна.


Дөрөв.2016 оны хичээлийн жилд бага ангийн суралцагчдын дунд IQ сэтгэх чадварын дугуйланд нийт 183 суралцагчийг хамруулан 7 хоногт анги бүр 1 цаг 30 минутаар 2 удаа хичээллэн суралцагчдыг хөгжүүлэн ажиллаж байна. Энэ хичээлийн жилд IQ сэтгэх чадварын дугуйланд суралцах хүүхдийн тоо өмнөх жилийнхээс 13 сурагчаар буюу 7%-иар ахисан үзүүлэлттэй байна.




Тав. 2016 оны сургуулийн сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 11 сарын 11-нд болж өнгөрлөө. Энэхүү тэмцээнд VI-XII ангийн нийт сурагчид хамрагдсан бөгөөд эрэгтэй 6 баг, эмэгтэй 4 баг нийт 50 гаруй хүүхэд авхаалж самбаа, хурд хүчээ сорилоо.

Зургаа.I Улирлын төгсгөлд “Үдийн цай” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч “Сүмбэр Шүтээн” ХХК-ийн үйл ажиллагаанд 3-р сургуулийн 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс хяналт шинжилгээ үнэлгээг хийлээ. Комиссын дүгнэлтээр 89%-тай шалгагдаж, цаашдын үйл ажиллагаанд зохих санамжийг хүргүүлээ.


Долоо. 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээ мэдээллийн дүн нэгтгэгдэж гарлаа. Энэ хичээлийн жилд манай сургууль нийт 627 суралцагчидтай сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Статистик мэдээ мэдээлэл нь БДБ мэдээлийг нэгдгэн гаргадгаараа давуу талтай болж багш нарын ажлын ачааллыг багасгасан сайн үйл ажиллагаа болсон. Тоон мэдээлийг графикаар үзүүлбэл:



Сурагчдын харьяаллын судалгааг аймаг орон нутгаар нь графикжуулан харуулбал:



Сургуулийн нийт суралцагчдын тоон үзүүлэлтийг графикжуулбал:



ЕБС-ийн 2016 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж хууль тогтоомж бодлогын баримтын хэрэгжилттэй танилцаж үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор аймгийн БСУГ-ын мэргэжилтнүүд манай сургууль дээр ирж ажиллалаа. Хяналт шинжилгээ үнэлгээ хийх багийн дүгнэлтэнд манай сургуулийн үйл ажиллагаа хэвийн явагдаж буйг танилцуулж цаашид анхаарч ажиллах тал дээр зөвлөн тусаллаа.

Гуравдугаар цэцэрлэг:

Нэг.2016 оны 11 сарын 04-нд “Хүүхдийг усаар чийрэгжүүлэх, хэл засал” сэдвээр 158 эцэг эхэд, 2016 оны 11 сарын 09-нд Шидэт хайрцагны театрын жүжигчид “Монголын шинэ ёс суртахуун, сэтгэлгээний шинэчлэл, ирээдүйгээ хайрлах энгийн нэгэн хайр бол гэр бүл дэх халуун уур амьсгал” сэдвээр 98 эцэг эхэд сургалт тус тус зохион байгууллаа.



Хоёр.Багш нар дараах сургалтанд хамрагдлаа. Үүнд:

- ✓ Шидэт хайрцагны театрын багш нарын “Шинэ үеийг бүтээх шинэ хандлага, шинэ харьцаа хаана бий болдог вэ?” сэдэвт сургалт;
- ✓ “Цахим гадуурхал цаашаа” сэдэвт сургалт;
- ✓ “Хүүхдийн эрхийн тухай” хууль, “Хүүхэд хамгааллын тухай хууль” сэдэвт сургалтанд тус тус хамрагдлаа.



Гурав.Аймгийн ХААГ–аас зохион байгуулсан газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулагддаг “Ургац-2016” уралдаанд амжилттай оролцож, “Тэргүүний байгууллага”-аар шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.

Дөрөв. Багш ажилчдын ажлын байранд хөгжүүлэх сургалт 2016 оны 11 дүгээр сарын 17-нд “Гар утасны хэрэглээ” “Цахим гадуурхал цаашаа”, “Хүүхдийн эрхийн тухай хууль, “Хүүхэд хамгаалах тухай хууль” сэдэвт сургалтыг зохион байгуулж 25 багш ажилчид хамрагдлаа.



Эрүүл мэндийн төв:

Нэг.Эрүүлмэндийнтөвийннүйлажиллагаахэвийнпявагдажбайна.11сардэмнэлэгтхэвтсэн 41,Амбулаторийннүзлэг550,Урьдчилансэргийлэх118,Дуудлага47

Хоёр.2016 оны 10 сарын 26-ны өдөр сумын нийт 176 иргэнээс Элэгний В,С вирус



илрүүлэх шинжилгээг хийн аймгийн төв лабораторид илгээгээд байна.

Гурав. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний төв, хамт олны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Сэтгэц, мэдрэлийн эмч Ц.Норсонг урьж авчран 2016 оны 10 сарын 28-ны өдөр сумын албан байгууллагуудын ажилтнуудад “Ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт зохион байгууллаа.



Дөрөв. 2015 оны 09 сард Эрүүл мэнд, спортын яамны захиалгаар Улсын төсвийн 960 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 ортой, 2 давхар, 3424,6 м² бүхий эмнэлгийн шинэ барилгыг хүлээж авах нээлтийн тууз хайчлах ёслолыг 2016 оны 11 сарын 11-ний өдөр зохион байгууллаа.



Тав. 2016 оны 11 сарын 03-нд Эрүүл мэндийн салбарын аудит шалгалтын нээлтийн үйл ажиллагааг аймгийн Эрүүл мэндийн газарт хийж, тус шалгалт сумын Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч, няравын үйл ажиллагаанд 10 хоногийн хугацаанд хийгдэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ДӨРӨВ: УЛСЫН БҮРТГЭЛ

- Иргэний бүртгэлийн үйлчилгээг 105 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 20 иргэнийг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.
- Газраа анх удаа өмчилж авч байгаа 103 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 103 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна.
- Иргэдээс энэ сард Иргэний бүртгэлтэй холбоотой 69, газартай холбоотой 15, нийт 84 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.

- Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2016 ОНЫ 11 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	90				90	46	44
Төрсөн эх	2	88				88		88
Бүртгүүлсэн гэр бүл	3	22				22	22	22
Нас баралт	4	22				22	10	12
Цуцалсан гэр бүл	5	4				4	4	4
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	108				108	65	43
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	90				90	38	52

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2016 оны 101р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Иргэний үнэмлэхний үнэ	15000	21	315000	3300	21	69300	
2	Эцэг тогтоолт	2500	6	15000				
3	Гэрлэлтийн гэрчилгээ	2500	1	2500				
4	Төрсний гэрчилгээ дахин авалт	5000	1	5000				
ДҮН		335000			69300			
НИЙТ ДҮН		404300						

ТАВ: НИЙГМИЙН ДААТГАЛ

- Эрүүл мэндийн шимгэл сайн дураар төлдөг иргэд 3-р улирлын байдлаар 4,139,280 төгрөгийн орлого төвлөрсөн байна.
- Эрүүл мэндийн даатгалаар төрөөс нийт 209 иргэнд үйлчилсэнээс:
 - Групптэй иргэн- 27
 - Өндөр настан- 53
 - 17 хүртлэх насны хүүхэд-56
 - 0-2 настай хүүхэдтэй эх - 73 тус тус хамрагдсан байна.

ЗУРГАА: ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Шивээ-Овоо ХК-аас зорилтот бүлгийн өрхийн 3-н хүүхдэд тус бүр нь 900000 төгрөгийн үнэ бүхий дүрэмт хувцас, өвлийн хувцасны тусламж үзүүллээ.



ДОЛОО: МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ТАСАГ

- Аймгийн ЗДТГ болон ХХААГ-ын “Ургац-2016” уралдаанд сумын ногоочин Т.Ганбаатар, 3-р цэцэрлэг нар тус тус тэргүүн байр эзэлсэн.



- Сумын Засаг даргын А/123 дугаар “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлын хэсэг томилох тухай” захирамжийн дагуу 10 дугаар сарын 21-ний өдрөөс вакцинжуулалтын ажил эхэлж 67 өрхийн 45100 толгой бог мал хамрагдсан.

- Аймгийн Онцгой байдлын газрын байцаагч нартай сумын ААН-үүдийн галын аюулгүй байдлын шалгалтыг хийсэн.



- МУЗГ-ын “Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 322 дугаар тогтоолын дагуу сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд одоогийн байдлаар 23,6 тн өвс татан бэлтгэсэн. Мөн 6,75 тн тэжээл худалдан авахад бэлэн болоод байна.

НАЙМ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ

Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Өргөх станцын барилга, шугам хоолой, тоног төхөөрөмжийн их засвар”-ын ажилыг Селенасибирь ХХК хийж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгөөд байна.

Мэдээ боловсруулсан:

НЗЭЗАХМэргэжилтэн

Б. Мөнхцэцэг